

ТҮНШЛЭЛИЙН ГЭРЭЭ

20.. оны дугаар
сарын-ний өдөр

№

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг нэг талаас: “.....” ХХК-ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал /цаашид “А” тал гэх/,

нөгөө талаас: “.....” ХХК-ийг төлөөлж, Гүйцэтгэх захирал /цаашид “Б” тал гэх/,

“.....” ТББ-ыг төлөөлж, Дарга /цаашид “В тал”, хамтад нь “Түншлэл” буюу “Талууд” гэх/ нар Монгол улсын “Иргэний хууль”-ийн 476 дугаар зүйлийг үндэслэн, харилцан ашигтай хамтран ажиллахаар харилцан тохиролцож байгуулсан болно.

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь талууд “Нийслэлийн орон сууцны корпораци” ОНӨААТҮГ-аас зарласан дугаар “Зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох” тендерт хамтран оролцох, Захиалагчтай байгуулсан гэрээний дагуу Сонгинохайрхан дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт хэрэгжих “Оргил төсөл”-ийн талбарын судалгаа, барилгажилтын зураг төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэх, хамтын үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, Түншлэлийн гишүүдийн хамтран болон тус тусдаа хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2 Түншлэлийн гишүүн тус бүрийн хуулийн этгээдийн эрх зүйн статус нь дор дурдсан хуулийн хүчин төгөлдөр баримт бичгээр тодорхойлогдоно.
 - 1.2.1 Түншлэлийн “А тал” буюу “.....” ХХК – Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - 1.2.2 Түншлэлийн “Б тал” буюу “.....” ХХК – Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ;
 - 1.2.3 Түншлэлийн “В тал” буюу “.....” ТББ – Улсын бүртгэлийн дугаар, Регистрийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ.
- 1.3

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээ нь 20... оны дугаар сарын-ний өдөр талуудын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж, талууд энэхүү гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлснээр дуусгавар болно.
- 2.2 Талуудын хамтын ажиллагаа нь тендерийн иж бүрдэлд хамаарах бичиг баримтыг тал тус бүр бүрдүүлснээр эхлэх ба тендерт өрсөлдөн шалгарч, Захиалагчтай үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулсан нөхцөлд гэрээний хэрэгжилтийг Захиалагчийн өмнө бүрэн биелүүлж дуусах хүртэл хугацаанд үргэлжилнэ.



- 2.3 Тендер шалгаруулалтын үр дүнг нийтэд зарласан өдөр Түншлэл нь тендерт шалгарч чадаагүй тохиолдолд энэхүү гэрээний хугацаа шалгаруулалтын үр дүнг нийтэд зарласан өдрөөр дуусгавар болно.

Гурав. Баталгаа, мэдэгдэл

- 3.1 Түншлэлийн гишүүн бүр Монгол улсын холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй, тендерийн шалгаруулалтын бичиг баримтад заасан доорх нөхцөл байдал тухайн хуулийн этгээдэд үүсээгүй болохыг батлан мэдэгдэж байгаа болно. Үүнд:

3.1.1 Төлбөрийн чадваргүй болсон, татан буугдаж байгаа, дампуурлаас зайлсхийх зорилгоор зээлдүүлэгчтэй тохиролцсон, бизнесийн үйл ажиллагааг нь зогсоосон;

3.1.2

- 3.2

Дөрөв. Талуудын хамтын үйл ажиллагаа, хөрөнгө санхүү

.....

Тав. Түншлэлийн удирдлага, зохион байгуулалт

- 5.1 Түншлэлийн хамтын үйл ажиллагааг “А тал” /цаашид “Түншлэлийн удирдагч” гэх/ бүхэлд нь удирдан, зохион байгуулж ажиллана.
- 5.2 Түншлэлийн удирдагч нь Захиалагчаас зарласан тендер шалгаруулалтын хүрээнд Түншлэлийг бүрэн төлөөлөх эрхтэй ба Захиалагчтай гэрээ байгуулсан нөхцөлд Түншлэлийг төлөөлж, аливаа гэрээ хэлцэлд гарын үсэг зурах бүрэн эрхийг эдэлнэ.
- 5.3 Түншлэлийн удирдагч нь Түншлэлийн хамтын үйл ажиллагааг бүхэлд нь зохион байгуулж, талуудын хамтарсан хурлыг хуралдуулах, хурал даргалах, хурлын тэмдэглэлийг хөтлүүлэх, хяналт тавих эрхтэй.
- 5.4

Зургаа. Түншлэлийн “А тал”-ын эрх, үүрэг

- 6.1 Түншлэлийн “А тал” нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

6.1.1 Төслийн төвлөрсөн дансанд тендерийн мөнгөн хөрөнгийг төвлөрүүлж, төслийн үйл ажиллагаанд захиран зарцуулах;

6.1.2 Түншлэлийн гишүүдийн үйл ажиллагаанд хяналт, шаардлага тавих;

6.1.3

- 6.2 Түншлэлийн “А тал” нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

6.2.1 Төслийг хэрэгжүүлэх хугацаанд иргэдтэй уулзах, Түншлэлийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгөх;

6.2.2 Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөг боловсруулах, төсөв тооцооллыг хийж гүйцэтгэх;

6.2.3

Долоо. Түншлэлийн “Б тал”-ын эрх, үүрэг

7.1 Түншлэлийн “Б тал” нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 7.1.1 Түншлэлийн “А тал”-аас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 7.1.2 Зураг төслийн ажлын хөлс, төлбөрийг тогтоосон хугацаанд төлөхийг шаардах;
- 7.1.3

7.2 Түншлэлийн “Б тал” нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 7.2.1 Мэргэжлийн өндөр түвшинд зураг төслийг боловсруулан, магадлал хийлгэж, тогтоосон хугацаанд Түншлэлийн удирдагчид хүлээлгэн өгөх;
- 7.2.2 Өөрийн гүйцэтгэсэн зураг төсөлтэй холбогдох тайлбар, тодруулгыг тухай бүрт өгч ажиллах;
- 7.2.3

Найм. Түншлэлийн “В тал”-ын эрх, үүрэг

8.1 Түншлэлийн “В тал” нь дараах эрхийг эдэлнэ. Үүнд:

- 8.1.1 Түншлэлийн “А тал”-аас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;
- 8.1.2 Иргэдэд мэдээлэл өгөхөд шаардлагатай баримт бичиг, мэдээллээр хангахыг Түншлэлийн гишүүдээс шаардах;
- 8.1.3

8.2 Түншлэлийн “В тал” нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- 8.2.1 Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдтэй харилцаа холбоо тогтоох, байнгын харилцаа холбоотой ажиллах, шаардлагатай мэдээллээр хангах;
- 8.2.2 Төсөл, Түншлэлийн үйл ажиллагааны талаар иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх, уулзалт зохион байгуулах;
- 8.2.3

Үргэлжлэл бий /9х/

